



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/103

Мандалговь

Г

Т


Журам хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Авлигатай тэмцэх газрын 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Авлигатай тэмцэх газрын 2019 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн зөвлөмжөөр өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлж аймгийн Засаг даргын 2014 оны А/316 дугаар захирамжаар баталсан "Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх, Бэлэг, дурсгалын зүйл гардуулах хөрөнгө зарцуулах журам"-ыг хүчингүй болгосугай.

Хоёр. Аймаг, орон нутгийн удирдлагаас гадаад, дотоодын зочин төлөөлөгчдөд хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх, бэлэг, дурсгалын зүйл гардуулахдаа Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолоор баталсан "Төр засгийн шугамаар гадаад, дотоодын зочин төлөөлөгчдөд хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын норматив", "Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам"-ыг мөрдлөг болгож ажиллахыг Засаг даргын Тамгын газар(Ц.Эрдэнэсүрэнд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190490